

2025 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 27-НЫ ӨДРИЙН
ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨНД НИЙСЛЭЛ, ДҮҮРГИЙН УДИРДАХ
АЖИЛТНААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР

Үүргийн биелэлтийг Arial-11 фонтоор бичиж, **2025 оны 01 дүгээр сарын 31-ний “Баасан” гарагийн 12:00 цагаас өмнө** Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Тогтоол шийдвэрийн биелэлт хариуцсан мэргэжилтэн (ERP Б.Одбаяр)-д албан бичгээр болон word файлаар ирүүлнэ үү.

Нийслэл, дүүргийн удирдлагаас цаг үеийн холбогдолтой өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтэд онцгой анхаарч биелэлтийг ирүүлэхдээ нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1106 дугаар захирамжаар батлагдсан “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх журам”-ын 8.6 дахь хэсэгт заасан дараах шаардлагын дагуу тайлагнахыг анхаарна уу

8.6.Байгууллагаас ирүүлэх бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилт, холбогдох тайлан, мэдээ нь дараах шаардлагыг хангасан байна:

8.6.1. үйл ажиллагааны гүйцэтгэлийг бүрэн багтаасан, тайлант хугацааг бүрэн хамруулсан байх.

8.6.2. үг үсгийн болон хэл найруулгын хувьд алдаагүй, тоо баримт зөрөөгүй байх;

8.6.5. тайлан дахь хүрсэн түвшний талаарх мэдээллийн үнэн, зөв эсэхийг нягтлан шалгасан байх;

8.6.6. хийсэн ажлыг бүрэн хамруулж, үйл ажиллагааны үр дүн, гүйцэтгэлд сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлийн үндэслэл, шалтгааныг тодорхой гаргасан байх;

8.6.7. хэрэгжилтийг 2000 (хоёр мянган) тэмдэгтэд багтааж, үр дүн, үр нөлөөг тайлагнах

№	Өгсөн үүрэг даалгавар	Хариуцах эзэн
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГАААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР		
2025 ОНЫ “БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН ЖИЛ”-ИЙН ХҮРЭЭНД		
1	Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын хүрээнд хийгдэх ажлуудын бэлтгэлийг сайтар хангаж, худалдан авах ажиллагааг ил тод, нээлттэй байдлаар зохион байгуулах.	СТСХ, ХААА
2	Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлын хүрээнд газар чөлөөлөлтийн ажлыг үе шаттайгаар зохион байгуулах бэлтгэл ажлыг сайтар хангах.	ЗДТГ, ГЗБА
3	Теле хяналтын камерын дэд төвийн засварын ажлыг дуусгаж, дэд камерыг холбох ажлуудаа шуурхай зохион байгуулж, ажлыг эхлүүлэх.	ЗДТГ, Цагдаагийн хэлтэс
АГААРЫН БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ АЖЛЫН ХҮРЭЭНД		
4	Хүнсний, бараа, бүтээгдэхүүний эрүүл ахуй, чанар, стандарт, сав баглаа боодлыг битүүмж, шаардлага хангуулах, аюулгүй байдлыг хяналт шалгалтын ажлуудыг шуурхай зохион байгуулах.	ТХҮХ
5	Ерөнхий боловсролын сургуулийн хичээл эхэлж байгаатай холбогдуулан томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлж, сургалтын байгууллагын суралцагч, багш, ажилтан, албан хаагчдыг дотоод орчинд амны хаалтыг тогтмол зүүлгэх, мэргэжлийн байгууллагын өгсөн зөвлөмж, зааврыг хэрэгжүүлэх захирамж гаргах.	Боловсролын хэлтэс, ЭМТ, ЕБС, СӨББ-ууд
6	Эрүүл мэндийн байгууллагуудын гадна орчны аюулгүй байдал болон дотоод орчны угаалга,	НХХ, ЭМТ

	цэвэрлэгээ, ариутгал, халдваргүйжүүлэлт, шавьж, мэрэгч устгалын үйл ажиллагаанд онцгой анхаарч, төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг зохион байгуулах.	
ЦАГ ҮЕИЙН БУСАД АСУУДЛЫН ХҮРЭЭНД		
7	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын удирдлагууд “Шуурхай штаб”-ыг шаардлагатай мэдээ, мэдээллээр түргэн шуурхай хангаж, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлж ажиллах, үүнтэй холбогдуулан дүүрэг орон нутагт болон тухайн салбарт тулгамдаж буй хууль эрх зүйн саад бэрхшээл, УИХ, ЗГ-аас дэмжлэг тусалцаа хүсэх ямар асуудал байгаа талаар байгууллагуудаас холбогдох саналыг авч нэгтгэн хүргүүлэх.	ЗДТГ, Нийт байгууллагууд
8	Нийслэлийн хэмжээнд 2025 оны 2, 3, 4 дүгээр саруудад соён гэгээрүүлэх чиглэлээр урлаг, соёлын арга хэмжээ, спортын тэмцээн уралдаан, наадам зэрэг олон нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулахтай холбогдуулан дүүргийн зүгээс саналыг хүргүүлж, холбогдох арга хэмжээг зохион байгуулах.	НХХ, БТСХ, Соёлын ордон
9	Эрүүл мэндийн байгууллагууд болон ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүдэд соён гэгээрүүлэх чиглэлээр цогц арга хэмжээ зохион байгуулах.	НХХ, ЭМТ, ЕБС, СӨББ-ууд
10	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд ажилтан, албан хаагчдаа эрүүл мэндийн үзлэгт хамруулах ажлыг зохион байгуулах.	ЭМТ, Нийт байгууллагууд
11	Сар шинийн баярыг угтан зохион байгуулагдах үзэсгэлэн худалдаа, арга хэмжээнийний зохион байгуулалтад анхаарч холбогдох байгууллагуудын уялдаа холбоог хангаж ажиллах.	Дүүргийн менежер, ТХҮХ, ЖДҮҮДТ, Соёлын ордон
ХОТ НИЙТИЙН АЖ АХУЙН АСУУДЛЫН ХҮРЭЭНД		
12	Нийслэлийн хэмжээнд хог хаягдлын менежментийг сайжруулах бодлогын баримт бичгийг боловсруулах ажлыг гүйцэтгэхтэй холбогдуулан дүүргээс холбогдох саналыг хүргүүлэх, хог их хаядаг байршлуудад хяналтын камер суурилуулах ажлыг зохион байгуулах.	Дүүргийн менежер, ТХҮХ
13	Дүүргүүд өөрсдийн нутаг дэвсгэртээ цас мөс, хог хаягдал цэвэрлэх, тээвэрлэх үйл ажиллагаагаа эрчимжүүлж, түүний хэрэгжилтэд хяналт тавих улсын байцаагч ажиллуулах, бүтэц орон тооны асуудлыг зохицуулах захирамж гаргах хүрээнд холбогдох саналыг хүргүүлэх.	
14	Ил задгай хог хаягдал хөглөрч, хүмүүсийн эрүүл, цэвэр орчинд амьдрах эрх зөрчигдөж байгаатай холбоотой хог хаяхыг хориглосон цагийн зохицуулалтын захирамжийн төслийг боловсруулахтай холбогдуулан холбогдох саналыг хүргүүлэх.	
15	Суурьшлын бүсээс мал гаргах ажлыг зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах.	ЗДО Х.Цогцэцэг, ХААТ
ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР		
16	Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч 02 дугаар сард дүүрэгт ирж ажиллахтай холбогдуулан холбогдох бэлтгэлийг сайтар хангаж ажиллах. (Энэ хүрээнд 2025 онд	ЗДТГ

	дүүрэгт хийгдэх тохижилтын ажлын танилцуулга бэлтгэх)	
17	Нийслэлийн Засаг даргын 2025 оны “Сахилга хариуцлага, төрийн үйлчилгээг сайжруулах талаар авах зарим арга хэмжээний тухай” А/62 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангаж сар бүрийн 22-ны өдрийн дотор биелэлтийг ирүүлэх.	ЗДТГ, Холбогдох байгууллагууд
18	Дүүргийн хэмжээнд 2025 онд хийгдэх зам засварын ажлын гүйцэтгэлийг тогтоосон хугацаанд шуурхай зохион байгуулж, чанар, стандарт, аюулгүй байдлыг хангуулах бэлтгэлийг сайтар хангах.	ЗДТГ, Гүйцэтгэгч байгууллага
19	2025 оны 02 дугаар сарын 04-ний өдөр зохион байгуулагдах “Түншлэл-Үйлчилгээний соёлыг дээшлүүлэх жил”-ийн нээлтийн арга хэмжээг зохион байгуулах бэлтгэлийг ханган, ААНБ-уудыг идэвхтэй оролцуулах.	ЗДО Х.Цогцэцэг ЗДТГ, Нийт байгууллагууд
20	Эрүүл мэндийн төвийн дэргэдэх Сувиллын үйл ажиллагааг эхлүүлэх боломж нөхцлийг бүрдүүлэх.	ЗДО Х.Цогцэцэг, НХХ, ЭМТ
21	Хүү, торгуулийн орлогын тодорхой хувийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зарцуулах талаарх зохицуулалтыг үндэслэн камержуулалтыг бүрэн шийдэх хүрээнд холбогдох орлогод нийцүүлэн тооцооллыг хийх.	ЗДО Х.Цогцэцэг, ЗДТГ, Цагдаагийн хэлтэс
22	Том оврын автомашины граж барих ажлыг холбогдох боломж нөхцөлийн хүрээнд гүйцэтгэх ажлыг зохион байгуулах, тооцооллыг хийж танилцуулах.	Дүүргийн менежер, ТХҮХ, Багахангай тохижилт ОНӨААТҮГ
23	44 дүгээр цэцэрлэгт үүссэн нөхцөл байдлыг яаралтай арилгах арга хэмжээг холбогдох байгууллагууд зохион байгуулах.	Холбогдох байгууллагууд

БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР